



ХОВД АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН ТУШААЛ

2024 оны 11 сарын 20 өдөр

Дугаар А/24

Ховд

Аудитын тайлан баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1 дэх заалт, 29 дүгээр зүйлийн 29.4 дэх хэсэг, Монгол улсын Ерөнхий аудиторын 2023 оны 10 дугаар сарын 5-ны өдрийн А/102 дугаар тушаалын 4 дүгээр хавсралтын 1.4 дэх хэсэг, 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан "Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам"-ын 18.9 дэх хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Төрийн байгууллагын хүний нөөцийн бодлого, тогтолцооны, үр нөлөө"-д хийсэн гүйцэтгэлийн аудитын тайланг нэгдүгээр хавсралтаар баталгаажуулсугай.

2. Аудитын зөрчлийн нэгтгэлийг хоёрдугаар хавсралтаар баталсугай.

3. Аудитын тайланг Гүйцэтгэл, нийцлийн аудитын газар, Төрийн албаны зөвлөлийн Ховд аймаг дахь салбар зөвлөл, Ховд аймгийн Засаг даргад тус тус хүргүүлсүгэй.

4. "Төрийн байгууллагын хүний нөөцийн бодлого, тогтолцооны, үр нөлөө"-д хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлангаар өгөгдсөн албан шаардлага, зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллаж, үр дүнг 2025 оны 1 дүгээр сарын 25-ны дотор ирүүлэхийг Төрийн албаны салбар зөвлөл, Аймгийн засаг даргад зөвлөсүгэй.

5. Ажлын болон нотлох баримтын иж бүрдлийг ханган архивд хүлээлгэн өгөхийг аудитор (Д.Энхжаргал)-д, албан шаардлага, зөвлөмжийн биелэлтэд хяналт тавьж, гүйцэтгэлийн аудитын цахим системд иж бүрэн оруулахыг Гүйцэтгэлийн аудитын багт хариуцуулсугай.

6. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж, удирдлагыг мэдээллээр хангаж ажиллахыг аудитын менежер (А.Цэцэгсүрэн)-д даалгасугай.

ДАРГА,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Х.БОЛДБААТАР



Тушаал-2024



**ХОВД АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

84140 Ховд Жаргалант сум, Ховд аймаг  
Утас/Факс: 70433061

2024.12.06 № 465

Тангийн

-ны №

-г

**ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН  
ХОВД АЙМАГ ДАХЬ САЛБАР ЗӨВЛӨЛД**

Ховд аймгийн Төрийн аудитын газраас Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд "Төрийн байгууллагын хүний нөөцийн бодлого, тогтолцооны үр нөлөө" д хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлан хүргүүлж байна.

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5-д заасны дагуу зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг 2025 оны 01 дүгээр сарын 06-ны дотор ирүүлнэ үү

Хавсралт ... хуудастай

ДАРГА,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Х.БОЛДБААТАР

A5-тоот-2024



**ХОВД АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

34140 Ховд, Жаргалант сум, Ховд аймаг  
Утас/Факс: 70433081

2024.12.06 № 466  
Төрийн \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

**АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА  
М.АМАРСАНАА ТАНАА**

Ховд аймгийн Төрийн аудитын газраас Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд "Төрийн байгууллагын хүний нөөцийн бодлого, тогтолцооны үр нөлөө" -д хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлан хүргүүлж байна.

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5-д заасны дагуу зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг 2025 оны 01 дүгээр сарын 06-ны дотор ирүүлнэ үү

Хавсралт ... хуудастай

ДАРГА,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  Х.БОЛДБААТАР

A5-тоот-2024



ХОВД АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

84140 Ховд, Жаргалант сум, Ховд аймаг  
Утас/Факс: 70433061

2024.12.06 № 467

танил \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

ХОВД АЙМГИЙН ИРГЭДИЙН  
ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ДАРГА  
З.ЭРХБАЯР ТАНАА

Ховд аймгийн Төрийн аудитын газраас Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд "Төрийн байгууллагын хүний нөөцийн бодлого, тогтолцооны үр нөлөө"-д хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлан хүргүүлж байна.

Хавсралт ... хуудастай

ДАРГА,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  Х.БОЛДБААТАР

A5-тоот-2024



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬЯА  
ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

## ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

### “ТӨРИЙН БАЙГУУЛЛАГЫН ХҮНИЙ НӨӨЦИЙН БОДЛОГО, ТОГТОЛЦООНЫ ҮР НӨЛӨӨ”

ОРОН НУТАГТ ХҮНИЙ НӨӨЦИЙН БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГ БАТЛУУЛААГҮЙ, МЭРГЭЖЛИЙН  
БОЛОВСОН ХУЧИН ДУТАГДАЛТАЙ БАЙНА.

АУДИТЫН КОД: ХОА-2024/19-20-ШТА-ГА

Ховд хот

2024 он

Ховд аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,  
Тэргүүлэх аудитор: Х.Болдбаатар  
Утас: 70433061 Цахим хаяг: [Boldbaatar.khu@audit.gov.mn](mailto:Boldbaatar.khu@audit.gov.mn)  
Аудитын менежер: А.Цэцэгсүрэн  
Утас: 70432545 Цахим хаяг: [tsetsegsurena@audit.gov.mn](mailto:tsetsegsurena@audit.gov.mn)  
Ахлах аудитор: Д.Эрдэнэцэцэг  
Утас: 70432545 Цахим хаяг: [erdenetsetsegd@audit.gov.mn](mailto:erdenetsetsegd@audit.gov.mn)  
Аудитор: Д.Мөнхтулга  
Утас: 7043-2545 Цахим хаяг: [munkhtulgad@audit.gov.mn](mailto:munkhtulgad@audit.gov.mn)  
Аудитор: Д.Энхжаргал  
Утас: 7043-2545 Цахим хаяг: [enkhjargald@audit.gov.mn](mailto:enkhjargald@audit.gov.mn)  
Аудитор: Ц.Аззаяа  
Утас: 7043-2545 Цахим хаяг: [azzayats@audit.gov.mn](mailto:azzayats@audit.gov.mn)

<b>АГУУЛГА</b>	
Хүснэгтийн товъёог.....	3
Графикийн товъёог .....	3
Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдээгдэл.....	4
<b>ЕРӨНХИЙ ЗҮЙЛ 5</b>	
<b>БҮЛЭГ 1: ХҮНИЙ НӨӨЦИЙН БОДЛОГЫН БАРИМТ БИЧГИЙГ БОЛОВСРУУЛАН МӨРДӨХ ШААРДЛАГАТАЙ БАЙНА.....</b>	<b>6</b>
Төрийн байгууллагуудын бүтэц зохион байгуулалт нь дунд болон урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичигтэй нийцсэн байна.....	6
Төсвийн тухай хууль, Засгийн газрын тогтоол шийдвэрийг үндэслэн аймгийн Засаг даргын захирамжаар орон нутгийн байгууллагуудад 2-3 удаа бүтцийн өөрчлөлт хийгдсэн байна .....	7
Хүний нөөцийн бодлого, үйл ажиллагаанд хяналт хийж, арга зүйн зөвлөгөө өгсөн ч баримт бичгүүдийн стандарт шаардлага хангалтгүй байна.....	8
Сум орон нутагт боловсон хүчний нөөц хомсдолтой байгаагаас иргэд зарим төрийн үйлчилгээг авахад хүндрэлтэй байна.....	9
Төрийн байгууллагын үйлчилгээг цахимжуулан иргэдэд ил тод мэдээлэх талаар ахиц гарч байгаад иргэдийн цахимаар авах үйлчилгээний талаарх сургалт арга хэмжээг үе шаттай зохион байгуулах шаардлагатай байна.....	11
Төрийн байгууллагуудын чиг үүрэг, албан тушаалын давхардалд эрх бүхий байгууллагаас хяналт хэрэгжүүлээгүй байна.....	12
Сум орон нутагт мэргэжлийн боловсон хүчнийг тогтвор суурьшилтай ажиллуулах нийгмийн баталгаагаар хангах төрийн бодлогыг жигд хүртээмжтэй олгох шаардлагатай байна .....	13
Сул орон тооны мэдээллийг олон нийтэд, ил тод нээлттэй байдлаар хүргэж ажилласан зарим төрийн үйлчилгээний албан тушаалтныг сонгон шалгаруулалтагүйгээр томилж байна .....	14
Төрд учруулсан хохирлыг уг шийдвэрийг гаргасан буруутай албан тушаалтнаар нөхөн төлүүлэх хуулийн хэрэгжилт хангалтгүй байна.....	15
<b>БҮЛЭГ 2: ЦАХИМ МЭДЭЭЛЛИЙН ТОГТОЛЦООГ НЭВТРҮҮЛСНЭЭР ТӨРИЙН АЛБАНЫ ИЛ ТОД БАЙДАЛ САЙЖИРСАН Ч ЗАРИМ ТӨРИЙН АЛБАН ХААГЧ НАРЫН АЖЛЫН ХАРИУЦЛАГА, МЭДЛЭГ ЧАДВАР СУЛ БАЙНА.....</b>	<b>16</b>
Орон зайнаас үл хамааран мэдээ, мэдээллийг тухай бүр авч өөрийн мэдлэг чадвараа дээшлүүлэх боломж бүрдсэн байна .....	16
Албан тушаалын тодорхойлолтод заасан тусгай шаардлагыг хангасан төрийн албан хаагчдыг сэлгэн томилсон байна .....	17
Мэдээллийн технологийн чиглэлийн мэргэжилтэн хөдөө сумдад дутагдалтай байна ЗДТГ, чиг үүргийн дагуу ажиллуулж байна.....	17
Жендерийн тэгш байдлыг хангах дэд хөтөлбөрийг боловсруулан батлуулсан ч хүрсэн түвшин, үр дүнг тооцоогүй байна.....	18
Хөдөө орон нутагт боловсон хүчин дутмагаас эрэлт ихтэй улсын бүртгэлийн үйлчилгээ, газрын үйлчилгээг авахад чирээгдэл үүсэж байна .....	18
Цахим мэдээлэл солилцооны нэгдсэн системийг төрийн байгууллагуудын үйл ажиллагаанд нэвтрүүлсэн байна.....	19
Төрийн үйлчилгээний ил тод байдалд хөндлөнгийн байгууллага хяналт хэрэгжүүлээгүй байна .....	19
<b>АУДИТЫН ЗӨВЛӨМЖ.....</b>	<b>21</b>
<b>ШАЛГАГДАГЧ БАЙГУУЛЛАГААС ИРҮҮЛСЭН ТАЙЛБАР.....</b>	<b>23</b>
<b>ТУШААЛ, ЗӨРЧЛИЙН НЭГТГЭЛ.....</b>	<b>23</b>

## ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР

ААН	Аж ахуйн нэгж
АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
БШУС	Боловсрол шинжлэх ухааны сайд
БОЭТ	Бүсийн оношилгоо эмчилгээний төв
ГХБХБГ	Газрын харилцаа барилга хот байгуулалтын газар
ҮАГ	Үндэсний аудитын газар
УИХ	Улсын их хурал
НҮТББ	Нийгэмд үйлчилдэг төрийн бус байгууллага
МУЕА	Монгол Улсын Ерөнхий аудитор
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
ЕБС	Ерөнхий боловсролын сургууль
СӨБ	Сургуулийн өмнөх боловсрол
ТӨҮГ	Төрийн өмчит үйлдвэрийн газар
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ХААИС	Хөдөө аж ахуйн их сургууль
ХХҮГ	Хөдөлмөр халамж үйлчилгээний газар
ХХГБХГ	Хүүхэд хамгаалал, гэр бүл хөгжлийн газар
ХХААГ	Хүнс хөдөө аж ахуйн газар
ХНУМЦ	Хүний нөөцийн удирдлага мэдээллийн систем
ТАСЗ	Төрийн албаны салбар зөвлөл
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
ЗЕХ	Захиргааны ерөнхий хууль
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
ТАЗ	Төрийн албаны зөвлөл
ТӨХК	Төрийн өмчит хувьцаат компани
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ХНХЯ	Хөдөлмөр нийгэм хамгааллын яам
ЭМГ	Эрүүл мэндийн газар
ЭМТ	Эрүүл мэндийн төв
ЭХЭУБ	Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэл
ШШГГ	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар

### Хүснэгтийн товъёог

№	Тайлбар	Хуудасны дугаар
Хүснэгт 1	Аймгийн 2021-2023 оны нийт төрийн албан хаагчийн тоо	7
Хүснэгт 2	Захиргааны ерөнхий хуулийн хэрэгжилт	15
Хүснэгт 3	Төрийн албан хаагчийг сэлгэн томилсон мэдээлэл	16

### Графикийн товъёог

№	Тайлбар	Хуудасны дугаар
График 1	Хүний нөөцийн тоон мэдээлэл	7
График 2	ТБОНӨААТҮГ-ын ажилчдын бүрэлдэхүүн хөдөлгөөн	9
График 2	ТБОНӨААТҮГ-ын нийгмийн баталгаа	13

### Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл

Аудит хийх үндэслэл, бүрэн эрх:	Аудитыг Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Улсын Их хурлын Төсвийн байнгын хорооны 2023 оны 08 дугаар тогтоол, МУЕА-ын А/162 дугаар тушаалаар баталсан 2024 оны төлөвлөгөөг үндэслэн гүйцэтгэлээ.
Аудитын зорилт:	Төрийн байгууллагын хүний нөөцийн бодлого, тогтолцооны үр нөлөөнд гүйцэтгэлийн аудит хийж дүгнэлт гаргаж, зөвлөмж боловсруулан аудитын тайланг Аймгийн ИТХ болон холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулж, иргэд, олон нийтэд мэдээлэхэд аудитын зорилт чиглэгдсэн. Уг зорилтыг хангахын тулд дараах чиглэлээр аудитыг гүйцэтгэлээ. Үүнд: <ul style="list-style-type: none"><li>• Төрийн байгууллагын хүний нөөцийн бодлого, хууль эрх зүйг хэрэгжүүлэх тогтолцоо бүрдсэн эсэх;</li><li>• Төрийн байгууллагуудын хүний нөөцийн тогтолцоо нь сайн засаглалыг бий болгож байгаа эсэх;</li></ul>
Аудитын хамарсан хүрээ:	Аудитаар төрийн зорилт, чиг үүргийг хууль тогтоомжийн хүрээнд аймгийн Засаг даргын эрхлэх хүрээний байгууллагууд, Төрийн болон Орон нутгийн өмчит үйлдвэрийн газруудын хүний нөөцийн үйл ажиллагааг хамруулсан. Аудитын судалгаанд төрийн тусгай чиг үүрэг бүхий цэргийн анги, шүүх, прокурорын байгууллагууд, Булган дахь Гаалийн Газар зэрэг байгууллагууд хамрагдаагүй болно.
Аудитын арга зүй, шалгуур үзүүлэлт:	Аудитыг гүйцэтгэлийн аудитын стандарт АДБОУС 100, 300, 400, 3000-3100, 4000, Монгол Улсын төрийн аудитын стандарт MNS 6817-5:2020 Гүйцэтгэлийн аудитын зарчим, MNS 6817-6:2020 Нийцлийн аудитын зарчим, MNS 6817-7:2020 Гүйцэтгэлийн аудитын стандарт, MNS 6817-8:2020 Нийцлийн аудитын стандарт, "Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам"-ын дагуу аудитын зорилго, зорилт, асуултын шинжилгээний асуултад хариулт өгөхөд шаардагдах бүх төрлийн нотлох зүйл цуглуулан, баримтжуулан, тэдгээрийг нягтлан шалгах, дүн шинжилгээ, харьцуулалт, тулган баталгаажуулалт, түүвэрлэлт хийх, судалгаа явуулах арга зүйг ашиглан аудитын хөтөлбөр, горим, асуудлын шинжилгээний дагуу нотлох зүйл цуглуулж, аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж боловсруулав.
Аудитын бүрэлдэхүүн, хугацаа:	Тэргүүлэх аудитор Х.Болдбаатар хянан удирдаж, үе шатны хяналтыг аудитын менежер А.Цэцэгсүрэн хэрэгжүүлж, ахлах аудитор Д.Эрдэнэцэцэг, аудитор Д.Мөнхтулга, Ц.Азаяа, Д.Энхжаргал нар 2024 оны 09-р сарын 10-наас 11-р сарын 20-нийг хүртэл хугацаанд хийж гүйцэтгэв.
Аудитын тайлангийн бүтэц, түүнд тусгаагдах мэдээлэл:	Аудитын тайланг Төрийн аудитын газрын даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж батлуулан, Төрийн албаны салбар зөвлөл, Засаг дарга, холбогдох байгууллага, албан тушаалтанд хүргүүлж, Үндэсний аудитын газарт тайлан нэгтгүүлэв.
Хүндрэл бэрхшээл:	Аудитаар аймгийн 2013-2016 оны үйл ажиллагааны төлөвлөгөө, тайлан, хүний нөөцийн бүртгэл 2016, 2013-2015 оны ил тод байдлын тайлан, байгууллагуудын тоон үзүүлэлт, зэрэг мэдээлэл бүрэн олдохгүй байх хүндрэл үүссэн. Сүүлийн 11 жил хамарсан судалгааг гаргахад зарим байгууллагуудын архивын нэгж иж бүрэн бус, байгууллагын нягтлан бодогч, удирдлага, хүний нөөцийн албан хаагчдын мэргэжлийн ур чадвар сул байгаа нь аудитын судалгааг нэгтгэхэд бэрхшээл үүсгэлээ.

## ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

Төрийн албаны тухай хууль нь анх 1994 оны 12 дугаар сарын 30-ны өдөр батлагдаж, 1995 оны 6 дугаар сарын 01-ний өдрөөс мөрдөгдөж эхэлсэн байна. Дээрх хуулийг 2002 оны 6 дугаар сарын 28-ны өдөр, 2017 оны 12 дугаар сарын 07-ны өдөр шинэчлэн найруулж, хамгийн сүүлд 2020 оны 01 дүгээр сарын 23-ны өдөр хуульд нэмэлт оруулсан байна.

Ховд аймгийн Төрийн албаны салбар зөвлөлийн гаргасан төрийн албан хаагчийн улсын нэгдсэн тоо бүртгэлээр 2023 онд төрийн 190 байгууллага, 6060 албан хаагч бүртгэгдсэн байна.

Төрийн албаны зөвлөлийн 2022 оны "Аймаг дахь салбар зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэн батлах тухай" 138 дугаар тогтоолын дагуу Ховд аймаг дахь салбар зөвлөл 11 хүний бүрэлдэхүүнтэйгээр үйл ажиллагаагаа явуулж, салбар зөвлөлийн гишүүдийг мэргэжил, арга зүйн удирдлагаар ханган, Төрийн албаны зөвлөлийн Салбар зөвлөлийн ажиллах журамд заасан чиг үүргийг хэрэгжүүлэн ажилласан байна.

Тайлант хугацаанд Салбар зөвлөл 19 удаа хуралдан, 63 асуудал хэлэлцэж, 135 тогтоол гарган хэрэгжилтэд нь хяналт тавин ажиллаж, 254 албан бичиг хүлээн авч, 318 албан бичиг явуулсан байна.

Төрийн албаны чадавхыг бэхжүүлэх хүрээнд Аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт 25 дэд хөтөлбөрийг шинээр болон шинэчилж 11 дэд хөтөлбөрийг үргэлжлүүлэн шинэчлэн боловсруулж хэрэгжүүлэхээр тусгасан бөгөөд төрийн байгуулалтын чиглэлээр Стандарттай Ховд, Цахим Ховд, Хариуцлагатай тунгалаг төр, нийгмийн бодлогын чиглэлээр Монгол хэл бичиг, Тогтвортой хөгжлийн боловсрол, Чадварлаг багш, оюутан, сурагч, Чадварлаг эмч, мэргэжилтэн, Чанартай боловсрол, хууль эрх зүйн чиглэлээр Иргэний эрх зүйн боловсрол аймгийн дэд хөтөлбөрүүдийг хэрэгжүүлж байна.

Төрийн албаны зөвлөлийн 2023 оны 25 дугаар тогтоолоор баталсан "Төрийн албаны шалгалт өгөх болзол болон шатлан дэвшүүлэх, сонгон шалгаруулах журам"-ын дагуу Төрийн албаны зөвлөлийн <https://csc.gov.mn>, аймгийн албан ёсны <http://khovd.gov.mn/>, цахим хуудас болон аймгийн Засаг даргын Тамгын газрын болон Төрийн албаны зөвлөлийн Ховд аймаг дахь салбар зөвлөлийн пэйж хуудсаар тус тус дамжуулан иргэдэд ил тод, нээлттэй зарлан ажиллажээ.

Ховд аймгийн хэмжээнд <https://e-mongolia.mn/> төрийн үйлчилгээний бүртгэл, хяналтын системээр 25 төрлийн үйлчилгээг иргэдэд хүргэж, тайлант онд 11258 иргэд үйлчлүүлсэн байна. Мөн иргэдэд бүртгэлийн үйлчилгээг шуурхай жигд хүртээмжтэй хүргэх, үйлчилгээний арга хэлбэрийг боловсронгуй болгож, иргэдэд цахим үйлчилгээ үзүүлэх зорилтын хүрээнд 10 сумыг онлайн буюу цахим сүлжээнд бүрэн холбосон байна.

"Хариуцлагатай тунгалаг төр" хөтөлбөрийг 2018 оноос хэрэгжүүлж энэ хүрээнд аймгийн ЗДТГ, ИТХ-ын Ажлын алба зэрэг нутгийн захиргааны 9 байгууллагад олон улсын чанарын менежментийн тогтолцооны ISO-9001-2015 стандартыг нэвтрүүлсэн байна.



**ХОВД АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

84140 Ховд, Жаргалант сум, Ховд аймаг  
Утас/Факс: 70433061

2024. 11. 20 № 442  
таний \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -г

**ГҮЙЦЭТГЭЛ, НИЙЦЛИЙН  
АУДИТЫН ГАЗАРТ**

"Төрийн байгууллагын хүний нөөцийн бодлого, тогтолцооны үр нөлөө"-д хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлан, судалгааг хүргүүлэв. Хавсралт ... хуудастай.

ДАРГА,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР *Х. Болдбаатар* Х. БОЛДБААТАР



A5-тоот-2024

## **БҮЛЭГ 1: ХҮНИЙ НӨӨЦИЙН БОДЛОГЫН БАРИМТ БИЧГИЙГ БОЛОВСРУУЛАН МӨРДӨХ ШААРДЛАГАТАЙ БАЙНА**

**Төрийн байгууллагуудын бүтэц зохион байгуулалт нь дунд болон урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичигтэй нийцсэн байна.**

1.1.1 "Алсын хараа-2050", Шинэ сэргэлтийн бодлогын Төрийн бүтээмжийн сэргэлтийн бодлогыг тууштай хэрэгжүүлж, мэргэшсэн, хариуцлагатай төрийн албыг бэхжүүлэх, төрийн болон нутгийн захиргааны байгууллагуудад төрийн үйлчилгээний үндэсний стандарт нэвтрүүлэх, төрийн үйлчилгээг иргэдэд соёлтой, шуурхай, хүнд сурталгүй хүргэхэд онцгой анхаарч, хүртээмжийг улам сайжруулан чанарын шинэ шатанд гаргах зорилт дэвшүүлэн ажилласан байна.

1.1.2 Засгийн газрын 2021 оны "Аймгийн ИТХ-ын ажлын албаны бүтэц, аймаг, сумын иргэдийн төлөөлөгчдийн хурлын ажлын албаны орон тооны хязгаарыг тогтоох тухай" 376 дугаар тогтоолоор аймгийн ИТХ-ын ажлын албыг 12 хүртэл орон тоотойгоор баталсан.

1.1.3 Засгийн газрын 2021 оны "Аймгийн Засаг даргын Тамгын газрын бүтэц, орон тооны хязгаарыг тогтоох тухай" 377 дугаар тогтоолоор Ховд аймгийн ЗДТГ-ыг 57 хүртэл орон тоотой, аймгийн захиргааны удирдлагын бүтцийг Засаг дарга, Засаг даргын орлогч, Засаг даргын Тамгын газрын дарга байхаар 6 хэлтэс, 1 штабтай, аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээнд 25 агентлаг ажиллуулахаар тус тус баталж өгсөн байна.

1.1.4 Аймгийн эрүүл мэндийн салбарын байгууллагуудын үйл ажиллагааны стратеги, бүтэц нь Монгол улсын дунд, урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичигтэй нийцсэн байна.

1.1.5 Төрийн байгууллагууд хөгжлийн бодлогын баримт бичигтэй нийцсэн бүтэц орон тоогоор үйл ажиллагаа явуулж байгаа ч төрийн үйлчилгээг иргэдэд соёлтой, шуурхай, хүртээмжтэй хүнд сурталгүй хүргэх, хүртээмжийг улам сайжруулан чанарын шинэ шатанд гаргах зорилтыг хангах хүний нөөцийн бодлогын баримт бичгийг шат шатандаа боловсруулаагүй байна. Тухайлбал:

- Аймгийн засаг даргын эрхлэх асуудлын хүрээний судалгаанд хамрагдсан 190 байгууллага нь хүний нөөцийн бодлогын баримт бичиг баримт боловсруулан батлуулаагүй байна,
- Ховд дулааны станц ТӨХК-иас бусад Төрийн болон орон нутгийн өмчит аж ахуйн нэгжүүд нь хүний нөөцийн бодлогын баримт бичиггүй,
- Шинэ жаргалант ТҮК ОНӨААТҮГ-н удирдлагууд солигдсонтой холбоотойгоор өмнөх оны архивын баримтуудыг аудитад гаргаж өгөөгүй,
- Боловсролын салбарт 2022-2024 онд хэрэгжүүлэх хөгжлийн бодлого, стратеги төлөвлөгөөг үнэлж дүгнэсэн талаар баримт байхгүй, стратеги төлөвлөгөөний биелэлтийг жил бүр үнэлж дүгнээгүй,
- Биеийн тамир спортын газар, Соёл урлагийн газар, Байгаль орчны салбарын байгууллагууд хүний нөөцийн бодлогын баримт бичиггүй, хүний нөөцийн бодлого нь хөдөлмөрийн дотоод журам, өс зүйн дүрэм, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрөөр зохицуулагдаж байгаа ч хэрэгжилт тодорхойгүй,
- Аймгийн хэмжээнд 13 төрийн болон орон нутгийн өмчит байгууллага үйл ажиллагаа явуулж байгаагийн АЗЗА ТӨХК, Ховд дулааны станц ТӨХК, Ховд аймаг дахь Нисэх буудал, Шим-Ус ОНӨААТҮГ-уудаас бусад орон нутгийн өмчит ААН-үүд байгууллагын үйл ажиллагааны стратеги төлөвлөгөөгөө гаргаж батлуулаагүй байна.

**Төсвийн тухай хууль, Засаг газрын тогтоол шийдвэрийг үндэслэн аймгийн Засаг даргын захирамжаар орон нутгийн байгууллагуудад 2-3 удаа бүтцийн өөрчлөлт хийгдсэн байна**

1.1.6 Аймгийн хэмжээнд төсвийн байгууллага 177, орон нутгийн өмчит үйлдвэрийн газар 9, төрийн өмчит үйлдвэрийн газар 4 нийт 190 байгууллага төрийн үйлчилгээг 6060 орон тоотойгоор хүргэж байна. Аймгийн хэмжээний хүний нөөцийг хүснэгтээр харуулбал:


Хүснэгт-1. Аймгийн 2013-2023 оны нийт төрийн албан хаагчийн тоо

№	Он	Ховд аймгийн нийт хүн амын тоо	Идэвхтэй хүн ам	Ажил эрхэлж байгаа хүний тоо	Нийт төрийн албан хаагчийн тоо	Төрийн албан хаагчийн эзэлж буй хувь			Өсөлтийн хувь	
						Нийт хүн амд	Идэвхтэй хүн амд	Ажил эрхэлж байгаа хүн амд	Нийт хүн амын	ТАХ-ийн
1	2013	78,364	33,444	31,339	5084	6.5	15.2	16.2		
2	2014	81,479	33,606	29,667	5344	6.6	15.9	18	4	5.1
3	2015	83,127	36,004	32,895	5390	6.5	15	16.4	2	10.9
4	2016	85,325	40,117	34,061	5378	6.3	13.4	15.8	2.6	3.5
5	2017	87,363	39,669	34,300	5345	6.1	13.5	15.6	2.4	0.7
6	2018	88,447	39,626	36,289	5236	5.9	13.2	14.4	1.2	5.8
7	2019	88,078	40,356	35,783	5532	6.3	13.7	15.5	-0.4	-1.4
8	2020	88,974	33,260	30,809	5618	6.3	16.9	18.2	1	-13.9
9	2021	90,333	39,620	36,051	5564	6.2	14	15.4	1.5	17
10	2022	90,671	39,929	36,526	5926	6.5	14.8	16.2	0.4	1.3
11	2023	90,137	39,328	38,039	6060	6.7	15.4	15.9	-0.6	4.1

Эх сурвалж: ТАЗ-ийн статистик мэдээлэл

1.1.7 Улсын төсвийн байгууллагууд яам, агентлагийнхаа хүрээнд баталсан бүтэц орон тоогоор ажиллаж, аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын бүтэц орон тооны өөрчлөлтийг тогтоол, шийдвэрийг үндэслэн засаг даргын захирамжаар баталж үйл ажиллагаагаа явуулж байна. *График 1. Хүний нөөцийн тоон мэдээлэл*

1.1.8 Аймгийн Засаг даргын эрхлэх хүрээний байгууллагуудын 55 хувь буюу 2866 албан хаагч боловсролын салбарт, 21 хувь буюу 1080 албан хаагч эрүүл мэндийн салбарт, 11 хувь буюу 556 албан хаагч аймаг сумдын ЗДТГ, ИТХ-д, 9 хувь буюу 472 албан хаагч орон нутгийн өмчит ААН-д, 4 хувь буюу 210 албан хаагч Соёлын салбарт ажиллаж байна.



1.1.9 Эрүүл мэндийн тухай хуулийн 15 дугаар зүйлд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх байгууллагын төрлийг заахдаа БОЭТ гэсэн байгууллага байхгүй тул нэгдсэн эмнэлгийн стандартаар үйл ажиллагаагаа явуулж байна

1.1.10 Минжит булганы буян ОНӨААТҮГ, Тээлийн илч ОНӨААТҮГ, Мянган сүтэйн буян ОНӨААТҮГ, Дарви тохижилт үйлчилгээний компани ОНӨААТҮГ-ууд нь ТУЗ байхгүй тул

бүтэц орон тоог сумын Засаг дарга баталсан нь Компанийн тухай хуулийн 75.4<sup>1</sup>, 81.4.2<sup>2</sup> дахь заалтуудтай нийцээгүй байна.

1.1.11 Ерөнхий боловсролын сургуулийн багшаас бусад захиргааны удирдлага, бусад ажилтнуудыг томилохдоо үйлчлэгч нарын цэвэрлэх талбайн хэмжээг нарийвчилж тооцоогүй, хүүхдийн тоо хүрэхгүй байхад хичээл зохицуулагч, хичээлийн туслах ажилтан, номын санч зэргийг илүү орон тоогоор ажиллуулсан байна.

1.1.12 Дөргөн сумын ЭМТ-ийн 2023 оны бүтэц орон тоонд эм зүйч гэсэн батлагдаагүй орон тоонд албан хаагч томилсон байна.

1.1.13 Сангийн яамнаас хянасан орон тооноос аймгийн ИТХ 2, ЗДТГ 12, Санхүү, дотоод аудитын алба 4 орон тоогоор илүү ажиллаж байгаа нь аймгийн Засаг дарга бүрэн эрхийнхээ хүрээнд бүтэц орон тоогоо баталсантай холбоотой байна.

**Хүний нөөцийн бодлого, үйл ажиллагаанд хяналт хийж, арга зүйн зөвлөгөө өгсөн ч баримт бичгүүдийн стандарт шаардлага хангалтгүй байна.**

1.1.14 Аймгийн Засаг даргаас төрийн үйлчилгээний хариуцлагатай, шуурхай, ил тод байдлыг эрхэмлэн төрийн албан хаагчдын ажлын бүтээмжийг нэмэгдүүлж хяналтын тогтолцоог сайжруулах, цахим мэдээлэл солилцох урсгалыг шуурхай болгох зорилгоор төрийн үйлчилгээг операторын тогтолцоонд шилжүүлэн дотоод удирдлага, хяналтын суурь системийг нэвтрүүлсэн байна

1.1.15 Төрийн албаны зөвлөлийн даргын 2023 оны 81 дүгээр тушаалаар байгуулагдсан "Төрийн албаны тухай хууль тогтоомж, шинэтгэлийн бодлогын хэрэгжилт, ТАХ-ын гүйцэтгэлийн төлөвлөгөө, тайлагналт, хөгжлийн хөтөлбөртэй танилцаж зөвлөмж өгөх, төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийг олон нийтэд сурталчлах, төрийн албан хаагчдад сургалт зохион байгуулан ажилласан байна.

1.1.16 Аймгийн Эрүүл мэндийн газраас өөрийн харьяа байгууллагуудад төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус хяналт, шалгалтыг тогтмол хэрэгжүүлж илэрсэн зөрчил дутагдлыг байгууллагын удирдлагад танилцуулж илэрсэн зөрчлийг арилгах хугацаатай үүрэг даалгавар өгч ажиллажээ.

1.1.17 Ховд шинэ дулааны станц ТӨХК-ийн дотоод аудитор нь хүний нөөц болон албан тушаалын тодорхойлолтод дотоод хяналтыг хэрэгжүүлсэн, Нисэх буудлын үйл ажиллагаанд Иргэний нисэхийн ерөнхий газраас Засгийн газраас хэрэгжүүлсэн Шүүр ажиллагааны хүрээнд хяналтыг хэрэгжүүлэн ажиллаж илэрсэн зөрчлийг арилгасан байна.

1.1.18 Боловсролын байгууллагын зарим ажилтнууд сургуульд сурсан, үйлдвэр аж ахуйн газар ажил эрхэлж байсан хугацааг ажилласан жил тэтгэврийн даатгалын шимтгэл нөхөн тооцох тухай хуульд хамруулж баталгаажилтын хуудас авсныг төрийн алба хаасан хугацаанд оруулан тооцсон, төсөл хөтөлбөрийн нэгжид ажилласан хугацааг төрийн алба хаасан хугацаанд оруулан тооцсон, андар насны тэтгэвэр тогтоолгох үндэслэлээр чөлөөлөгдсөн төрийн албан хаагчдад нэг удаагийн буцалтгүй тусламж олгохдоо төрийн албанд ажилласан хугацааг буруу тооцож илүү олгосон 75.8 сая, дутуу олгосон 3.6 сая төгрөг байна

1.1.19 ЕБС, СӨБ-ын байгууллагуудын захирал, эрхлэгч нарын гаргаж байгаа А, Б тушаалуудын үндэслэл стандарт, шаардлага хангахгүй байна.

<sup>1</sup> Хувьцаат компани болон төрийн өмчийн компанийн төлөөлөн удирдах зөвлөл нь өс буюу түүнээс дээш гишүүнтэй байх ба тэдгээрийн гуравны нэгээс доошгүй хувь нь хараат бус гишүүн байна

<sup>2</sup> Дотоод хяналтын албаны удирдлага, ажилтныг томилох, цалин, урамшууллыг тогтоох санал боловсруулах

1.1.20 Булган, Мөст сумын Соёлын төвүүд нь архив албан хэрэг хөтлөлтийн тухай хууль, архив албан хэрэг хөтлөлтийн нийтлэг журам, холбогдох стандарт шаардлагыг хангаж ажиллаагүй тушаал шийдвэр, хурлын тэмдэглэл, өргөдөл гомдлын шийдвэрлэлт, хувийн хэрэг хүний нөөцтэй холбогдох баримт бичгээр архивын нэгж үүсгээгүй байна.

**Сум орон нутагт боловсон хүчний нөөц хомсдолтой байгаагаас иргэд зарим төрийн үйлчилгээг авахад хүндрэлтэй байна**

1.2.1 ТАСЗ-өөс албан тушаалын сул орон тоо нөхөх тусгай шалгалтыг 2021-2024 оны хооронд 4-11 удаагийн давтамжтайгаар зарлаж байгаа боловч өнөөдрийг хүртэл нөхөгдөөгүй орон тоонууд байгаагаас иргэдэд очих төрийн үйлчилгээний чанар, хүртээмжид сөрөг нөлөөлөл үзүүлж байна. Тухайлбал:

- *Үенч сумын санхүүгийн албаны даргын орон тоог 4-5 удаа зарласан ч одоог хүртэл шалгуур хангасан албан хаагч томилогдоогүй,*
- *Дарви, Цэцэг, сумдын газрын даамал 2022 оноос хойш төрийн албаны зөвлөлөөс зарласан ч нөхөгдөөгүй,*
- *Мөст суманд хууль эрх зүйн ажилтан, нийгмийн ажилтан, Дөргөн суманд эрх зүйч, хөдөө аж ахуйн газар тариалангийн мэргэжилтэн, байгаль хамгаалагч, Мянгад суманд хөдөө аж ахуйн газар тариалангийн мэргэжилтэн, Буянт суманд мэдээлэл технологийн ажилтан, байгаль орчны байцаагч, хөдөө аж ахуйн газар тариалангийн мэргэжилтэн Алтай суманд мэдээлэл технологийн ажилтан, хөдөө аж ахуйн газар тариалангийн мэргэжилтэн тус тус зарласан ч нөхөгдөөгүй,*
- *Байгаль орчны газрын сумдын байгаль хамгаалагчид ажилд томилогдоод 1 жил хүрэхгүй хугацаанд ажиллаад сэлгэн, шилжин томилогдохоор хүсэлт өгч ажлаасаа гарах тохиолдол түгээмэл гарч 6 сумын 7 байгаль хамгаалагчийн сул орон тоонд ажиллах хүнгүй ажлын байрны сонгон шалгаруулалт зарлагдсан,*
- *Соёл урлагийн байгууллагын хэмжээнд 2024 оны 9 дүгээр сарын байдлаар 12 орон тоо сул байгаагаас соёл урлагийн газарт 10 албан хаагч, салбарын 19 байгууллагад 2024 оны 9 сарын байдлаар гэрээт ажилтнаар 8, хавсран гүйцэтгэгчээр 7, 184 нийт албан хаагч ажиллаж байгаа бөгөөд СУГ болон соёлын төвүүдэд сул орон тоо 8 бий болсон,*
- *Эрүүл мэндийн газрын сул орон тоог нийт 11 удаа нээлттэй зарласан ч нөхөгдөөгүй,*
- *Сумдын ЭМТ-үүдэд их эмч 1, шүдний эмч 1, багийн эмч 7, сувилагч 4, эм баригч, эм зүйч 2, лаборант 1 дутагдалтай,*
- *Мэргэжилтэй боловсон хүчин нь Төрийн албаны ерөнхий шалгалт өгөөгүй (удаа дараа өгөөд тэнцээгүй), нөөцөд бүртгэлгүй*

1.2.2 Аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа ТБОНӨААН-ын албан хаагчдын цалин бага, төрийн албанд ажилласан жил нь тооцогддоггүй, ажиллах нөхцөл хүнд, орон нутгийн болон бусад нэмэгдэл цалин хөлс байхгүйгээс мэргэжлийн боловсон хүчин дутагдалтай байна.

1.2.3 Төрийн болон орон нутгийн өмчит аж ахуйн нэгжүүдэд 2012-2023 оны хооронд нийт 381 сул орон тоо гарсан, нийт 1,183 албан хаагч шууд болон түр, гэрээтээр ажилтнаар ажилд орж 1056 хүн ажлаасаа гарснаас үзэхэд цалин, нэмэгдэл бага, урамшуулал болон нийгмийн баталгаа хангах хөтөлбөр нь хангалтгүй, ажлын ачаалал их зэргээс голлон шалтгаалжээ

1.2.4 Цэцэг сутаин буян, Ховд суварга, Тээлийн илч, Минжит булган хот тохижилт, Мянган-Угалзат, Дарви тохижилт үйлчилгээний компани ОНӨААТҮГ-ууд нь албан тушаалын тодорхойлолт батлаагүй байхад гэрээ байгуулан ажиллаж цалинжуулжээ.

Төрийн болон орон нутгийн өмчит аж ахуйн нэгжийн албан хаагчдийн хөдөлгөөн График 1



1.2.5 Аймгийн хэмжээнд мэргэжлийн нийгмийн эрүүл мэнд судлалч гэсэн мэргэжилтэй боловсон хүчин байхгүйгээс Эрүүл мэндийн сайдын 2015 оны А/501 тоот тушаалаар баталсан нийгмийн эрүүл мэндийн ажлын байрны үлгэрчилсэн загварт тусгасан тусгай шаардлагыг тухайн эмчид зориулан өөрчлөн баталсан байна.

1.2.6 Эрүүл мэндийн газрын албан хаагчдын албан тушаалын тодорхойлолтод “Хүний их эмч” мэргэжил зааж өгсөн учраас эмч мэргэжлийн боловсон хүчин хомсдолтой, Бүсийн оношилгоо эмчилгээний төвөөс бусад эрүүл мэндийн салбар хүний нөөцийн судалгаагүй, аймгийн Эрүүл мэндийн газрын бүтэц орон тоог аймгийн Засаг дарга 2023 оны А/255 тоот захирамжаар батлахдаа 43 орон тоотойгоор үйл ажиллагаагаа явуулахаар заасан ч гүйцэтгэлээр 12 орон тоо дутуу ажилласан байна

1.2.7 Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хуулийн 14-р зүйлийн 14.3<sup>3</sup> 14.6<sup>4</sup> -д зааснаар сургууль цэцэрлэг сэтгэл зүйчтэй байхаар тусгасан байхад аймгийн 25 сургуулиас 17 нь мэргэжлийн сэтгэл зүйчтэй, 8 сургууль, 33 цэцэрлэг мэргэжлийн боловсон хүчний дутагдалтайгаас сэтгэл зүйчийн орон тоо дутуу явж ирсэн

1.2.8 Буянт сумын ЭМТ-ийн эрхлэгч эмчийн албан тушаалын тодорхойлолтод Эх барих эмэгтэйчүүдийн эмч мэргэжилтэй байхыг шаардсан,

1.2.9 Сумдын ЭМТ-үүд нь Эрүүл мэндийн сайдын баталсан албан тушаалын үлгэрчилсэн загварыг үйл ажиллагаандаа мөрддөггүй,

1.2.10 Булган сумын Нэгдсэн эмнэлгийн захирлын албан тушаалын тодорхойлолтод ажилласан жил нь их эмчээр 16 жил гэж заасан нь Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.3.1<sup>5</sup>-д заасан нэгдсэн эмнэлгийн гүйцэтгэх удирдлагын шаардлагыг зөрчжээ.

<sup>3</sup> ЕБС-д захирал, сурзалтын менежер, нийгмийн ажилтан, багш, сэтгэл зүйч, эмч, гомын санч болон холбогдох хууль тогтоомжид заасан ажилтан ажиллана  
<sup>4</sup> Цэцэрлэгт сэтгэл зүйч, хоол зүйч ажиллуулж болно  
<sup>5</sup> Эрүүл мэндийн салбарт 10-аас доошгүй жил ажилласан

**Төрийн байгууллагын үйлчилгээг цахимжуулан иргэдэд ил тод мэдээлэх талаар ахиц гарч байгаад иргэдийн цахимаар авах үйлчилгээний талаарх сургалт арга хэмжээг үе шаттай зохион байгуулах шаардлагатай байна**

1.2.11 Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан журмын 9 дүгээр хавсралтын дагуу “Ил тод байдлын шалгуур үзүүлэлтийн хэрэгжилт”-ийг тооцож, сум, байгууллагууд мэдээллийн самбар болон цахим сайтад байршуулан мэдээлсэн байна. Тухайлбал:

- Ховд аймгийн хэмжээнд <https://e-mongolia.mn/> төрийн үйлчилгээний бүртгэл, хяналтын системээр 25 төрлийн үйлчилгээг иргэдэд хүргэсэн,
- Иргэдэд бүртгэлийн үйлчилгээг шуурхай жигд хүртээмжтэй хүргэх, үйлчилгээний арга хэлбэрийг боловсронгуй болгож цахим үйлчилгээ үзүүлэх зорилтын хүрээнд 17 сумыг онлайн буюу цахим сүлжээнд бүрэн холбосон,
- Аймгийн Засаг даргын Тамгын газрын үйл ажиллагаатай холбоотой бодлогын баримт бичиг, эрх зүйн актыг батлагдсан тухай бүр нь <http://khovd.gov.mn/> цахим хуудас болон мэдээллийн самбарт байршуулж хэвшсэн,
- ГХБХБ-ын газар нь газар зэмших, ашиглах, өмчлөх эрхийн гэрчилгээ олгох, кадастрын зураг, сорилт шинжилгээ, хяналтын хэмжилт хийх, ажил эхлүүлэх, үргэлжлүүлэх зөвшөөрөл олгох зэрэг 15 чиглэлээр иргэд үйлчилгээ авахад шаардагдах бичиг баримтын жагсаалтыг <http://khovdغازar.mn/> цахим хуудас, мэдээллийн салбарт тогтмол байршуулж, өөрчлөлт, шинэчлэлтийг хийсэн
- Улсын бүртгэлийн хэлтэс нь иргэний бүртгэл, ЭХЭУБ, хуулийн этгээдийн бүртгэлийн чиглэлээр иргэд үйлчилгээ авахад шаардагдах бичиг баримтын жагсаалтыг <https://khovd.burigel.gov.mn/> цахим хуудас, мэдээллийн салбарт тогтмол байршуулдаг
- Хүний нөөцийн удирдлагын ил тод байдлыг хангах чиглэлээр авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний талаар аймгийн Засаг даргын Тамгын газрын <https://khovd.gov.mn/> цахим хуудсанд ойлгомжтой байдлаар байршуулан баяжилтыг тухай бүр хийсэн
- Төрийн байгууллагууд санхүүгийн үйл ажиллагааны мэдээллийг <https://shilendans.gov.mn> сайтад бүрэн байршуулж хяналт хэрэгжүүлж хэвшсэн
- Нутгийн захиргааны байгууллагуудын сул орон тоог нөхөх тусгай шалгалтын мэдээллийг ТАЗ, аймгийн цахим хуудсанд байршуулж, орон нутгийн Ховд, Олон ястны телевизээр нээлттэй зарлуулж иргэдэд мэдээлэл өгч хэвшсэн,
- Аймгийн эрүүл мэндийн газар нь <http://khovd.moh.gov.mn/>, Бүсийн оношилгоо эмчилгээний төв нь <http://khovdboet.mohs.gov.mn/> цахим сайтаар эрүүл мэндийн асуудлаар ард иргэдэд цаг үеийн болон ихээхэн илэрч байгаа өвчлөлөөс урьдчилан сэргийлэх санамж, үзлэгийн цаг авах, шаардлагатай орон тооны мэдээлэл зэрэг үйлчилгээг тогтмол хүргэж хэвшсэн байна.

1.2.12 Дээрх мэдээллийг ил тод болгож цахимд байршуулсан ч иргэдийн оролцоо идэвх сулаас мэдээллийг цахимаар авч чадахгүй байна. Тухайлбал:

- Аймгийн хэмжээнд нийт 17 сум, 89 байгууллагын 14198 мэдээллийг шилэн дансанд байршуулахаас 13890 мэдээллийг байршуулсан байна. Нийт байршуулсан 13890 мэдээллийн 12566 мэдээллийг хуулийн хугацаанд, 1324 мэдээллийг хугацаа хоцруулан оруулсан байна
- Цахим мэдээллийн иргэдэд хүрэх хүртээмжийг нэмэгдүүлэхийн тулд мэдээ мэдээллийг хэрхэн авах, ашиглах талаар гарын авлага, сургалт сурталчилгаа хангалтугүйгээс иргэд зарим үйлчилгээг авч чадахгүй гомдол бухимдал, хүлээлтийн дараалал байсаар байна
- БОЭТ нь баруун бүсийн иргэдэд үйлчилгээ үзүүлдэг тул дараалал ихтэй, эмчид үзүүлэх цахим цаг авсан ч цагтаа үзүүлж амждаггүй, ор хүрэлцээгүй зэрэг эмнэлгийн үйлчилгээ авахад хүндрэл бэрхшээл тулгарч байна.

**Орон нутгийн байгууллагуудад хүний нөөцийн асуудал хариуцсан мэргэжилтний орон тоог баталж ажиллах шаардлагатай байна**

1.2.13 Хөдөө орон нутагт шаардлагатай нарийн мэргэжлийн боловсон хүчнийг бэлтгэхэд дэмжлэг үзүүлэх зорилгоор нарийн мэргэжлийн эмч бэлтгэхэд 2024 онд 11 оюутанд 46.2 сая, малын их эмч мэргэжлээр 4 оюутныг үнэгүй сургах гэрээг Оросын холбооны улстай байгуулсан байна.

1.2.14 Орон нутгийн байгууллагуудад хүний нөөцийн асуудал хариуцсан мэргэжилтэн байхгүй,бусад албан хаагч хариуцан ажиллаж байгаагаас байгууллагын хүний нөөцийн талаар хэрэгжүүлэх бодлого тодорхойгүй, судалгаа баримт бичиг иж бүрэн бус, мэдээллийн системд эрхийг 2-3 ажилтан ашиглаж байна.

- *ЕБС, СӨБ-ийн байгууллагуудад хүний нөөц хариуцсан мэргэжилтэн байхгүй, хүний нөөцийн мэдээллийг сургалтын менежер, нарийн бичиг, нягтлан бодогч цэцэрлэгийн арга зүйч нар хариуцан ажилладаг*
- *Сумдын хүний нөөцийн ажлыг тамгын газрын дарга нь давхар хариуцдаг*
- *Зарим байгууллагуудын бичиг хэрэг хүний нөөцийг хариуцдаг*
- *9 орон нутгийн өмчит үйлдвэрийн газруудад хүний нөөц хариуцсан ажилтан байхгүй*

**Төрийн байгууллагуудын чиг үүрэг, албан тушаалын давхардалд эрх бүхий байгууллагаас хяналт хэрэгжүүлээгүй байна**

1.3.1 Авлигатай тэмцэх "Шүүр" ажиллагааны хүрээнд аймгийн Засаг даргын 2023 оны А/151 дүгээр захирамжаар 5 хүний бүрэлдэхүүнтэй байгуулагдсан ажлын хэсэг хяналт, шалгалт хийж Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг, орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газруудын зөрчилтэй томилгоо 17, ажлаас чөлөөлөгдсөн 3, мэдэгдэл хүргүүлсэн 8, чөлөөлөгдөөгүй 6 албан хаагч, сумдын хэмжээнд зөрчилтэй томилгоо 13, ажлаас чөлөөлөгдсөн 8, чөлөөлөгдөөгүй 5 албан хаагчтай холбоотой зөрчил илрүүлэн ажилласан байна.

1.3.2 Төрийн албан хаагчдын ажлын байрны тодорхойлолтод заагдсан шалгуур үзүүлэлтийг хангаагүй томилогдсон 8 төрийн албан хаагч байна.

1.3.3 Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг, орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газруудын дотоод хяналтын төлөвлөгөө байхгүй, төрийн албан хаагчийн хувийн хэргийн бүрдэл, гүйцэтгэлийн үнэлгээнд хяналт хэрэгжүүлээгүйгээс төрийн албан хаагчдын ажлын хариуцлага суларсан байна. Тухайлбал

- *Сумдын хүний нөөцийн ажлыг Засаг даргын тамгын газрын дарга нь давхар хариуцдагаас үндсэн ажил руугаа анхаарснаас байгууллагын ажилчдын бүртгэл мэдээлэлд баримтын шинэчлэл хийгээгүй албан хаагчийн архив, бүрдүүлэлт хангалтгүй,*
- *Орон нутгийн төсөвт байгууллагууд болон зарим агентлаг төрийн өмчит аж ахуйн тооцоот газрууд байгууллагынхаа бүтэц орон тоо, чиг үүргийн давхардалд хяналт тавьж ажиллаагүй,*
- *Хүний нөөцтэй холбоотой баримт материалыг түүвэрлэн үзэхэд Жаргалант сум, аймгийн ЗДТГ, ХХАА, Татварын хэлтэс, хүчний байгууллагууд, ХХҮГ, ХХГБХГ, ГХБХБГ, зэрэг газрууд шаардсан баримт материал ирүүлээгүй*

1.3.4 Олон улсын чанарын менежментийн тогтолцооны ISO-9001-2015 стандартыг 2018-2022 онуудад нэвтрүүлж, бүх шатны төрийн албан хаагчдын харилцаа хандлага, үйлчилгээний соёлыг дээшлүүлж, төрийн үйлчилгээний чанар, хүртээмж, шуурхай байдлыг нэмэгдүүлэхээр хэрэгжүүлсэн боловч аймгийн ЗДТГ, Мөст, Алтай, Буянт, Цэцэг, Ховд, Манхан сумд, зарим төрийн байгууллагуудын төрийн албаны бичиг баримтын стандарт шаардлага хангахгүй, эмх цэгцгүй, архивын бүрдүүлэлт хангалтгүй байна.

**Сум орон нутагт мэргэжлийн боловсон хүчнийг тогтвор суурьшилтай ажиллуулах нийгмийн баталгаагаар хангах төрийн бодлогыг жигд хүртээмжтэй олгох шаардлагатай байна**

1.3.5 Төрийн албаны тухай хуулийн 55 дугаар зүйлийн 55.3<sup>6</sup>, 62-р зүйлийн 62<sup>7</sup>, 63-р зүйлийн 63<sup>8</sup>-д заасны дагуу хуулийн хэрэгжилтийг ханган ажиллаж сум, байгууллагууд “Төрийн албан хаагчийн ажиллах нөхцөл, нийгмийн баталгаа хангах хөтөлбөр”, “Сургалтын хөтөлбөр”-ийг 4 жилийн хугацаатай боловсруулан хэрэгжүүлсэн байна.

1.3.6 Төрийн албан хаагчийн ажиллах нөхцөл, нийгмийн баталгаа хангах хөтөлбөрийн хүрээнд Төрийн албаны тухай хуулийн 59<sup>9</sup>, 60<sup>10</sup>, 61<sup>11</sup> дүгээр зүйлд заасны дагуу дараах тэтгэмж урамшуулал олгосон байна: Үүнд:

- Гадаад улсад болон нэг аймаг, хотоос нөгөө аймаг, хотод, түүнчлэн аймаг, хотын дотор ажиллахаар томилогдсон албан хаагчид тээврийн хэрэгсэл, ачаа тээш, зам хоногийн зардал, түүний гэр бүлийн болон асрамжид нь байдаг хүмүүст тээврийн хэрэгсэл, ачаа тээшний зардалд 40 албан хаагчид 12.2 сая төгрөг;
- Төрийн албан хаагч албан үүрэг гүйцэтгэж байхад бие махбодод нь гэмтэл учруулсан буюу эрүүл мэндийг нь бусад хэлбэрээр хохироосноос хөдөлмөрийн чадвараа түр алдсан, хөгжлийн бэрхшээлтэй болсон бол түүний авч байсан цалин, тэтгэвэр, тэтгэмжийн зөрүүг хөдөлмөрийн чадвараа түр алдсан буюу хөдөлмөрийн чадвар алдсаны тэтгэвэр авч байсан нийт хугацаанд нөхөн олгож, хохирлыг гэм буруутай этгээдээр нөхөн төлүүлэх зардалд 1 албан хаагчид 4.4 сая төгрөг;
- Эзлжийн амралтаараа өөрийн, эсхүл эхнэр /нөхөр/-ийн төрсөн нутаг явах бол ирэх, очих замын зардлыг, эсхүл магадлан итгэмжлэл бүхий эмнэлгийн байгууллагын шийдвэрээр дотоодын сувилалд сувилуулах бол ирэх, очих замын зардлыг тухайн үед мөрдөж байгаа автомашин, төмөр замын үнзлэгээгээр тооцож хоёр жилд нэг удаа олгох зардалд 11 албан хаагчид 2,5 сая төгрөг;
- Хууль тогтоомжид заасан бусад нөхөх төлбөрт 913 албан хаагчид 458,2 сая төгрөг
- Төрийн улс төрийн албан хаагчаас бусад төрийн албан хаагч өндөр насны тэтгэвэр тогтоологдох үндэслэлээр чөлөөлөгдсөн бол үндсэн цалингийн дунджаас ажилласан хугацааг нь үндэслэн тооцож нэг удаагийн буцалтгүй тусламжид 191 албан хаагчид 2,544,3 сая төгрөг;
- Албан үүрэг гүйцэтгэх явцад төрийн албан хаагчийн амь нас хохирсон тохиолдолд 60 сарын албан тушаалын үндсэн цалинтай тэнцэх хэмжээний нэг удаагийн буцалтгүй тусламжийг түүний ар гэрт нь олгох зардалд 10 албан хаагчид 33,3 сая төгрөг;
- Орон байраар хангагдахад төрөөс дэмжлэг үзүүлэх зардалд 31 албан хаагчид 13,8 төгрөг;
- Төрийн хөрөнгөөр 6 хүртэлх сарын хугацаагаар давтан сурах, мэргэшилээ дээшлүүлэх сургалтад хамрагдах, энэ хугацаанд эрхэлж байгаа албан тушаалын цалинд 142 албан хаагчид 241,8 сая төгрөг;
- Ажлын зайлшгүй шаардлагаар эзлжийн амралтаа биеэр эдэлж чадаагүй төрийн захиргааны албан хаагчид түүний зөвшөөрснөөр 1.5 сарын албан тушаалын цалинтай тэнцэх мөнгөн урамшуулалд 25 албан хаагчид 45,5 сая төгрөг тус тус олгожээ.

<sup>6</sup> “Төрийн байгууллага төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны хөтөлбөрийг боловсруулж хэрэгжүүлнэ.”

<sup>7</sup> Төрийн жинхэнэ албан хаагчийн нэмэгдэл баталгаа

<sup>8</sup> Дүрэмт хувцас хэрэглэх эрх бүхий төрийн албан хаагч

<sup>9</sup> Төрийн албан хаагчид олгох нөхөн төлбөр


<sup>10</sup> Төрийн албан хаагчид олгох тусламж

<sup>11</sup> Төрийн албан хаагчийн нийтлэг баталгаа

1.3.7 Төрийн болон орон нутгийн өмчит аж ахуйн нэгжүүд нь нийгмийн баталгаагаар хангахаар хөдөлмөрийн дотоод журам болон нийгмийн баталгаагаар хангах хөтөлбөртөө тусган ажилласан байна.

1.3.8 2013-2023 оны хооронд ТӨХК-ууд нь нийт 185 ажилтанд 168.9 сая төгрөг, ОНӨААН-үүд нь 903 ажилтанд 106.7 сая төгрөгийг нийгмийн баталгаа хангах хөтөлбөрийн хүрээнд олгосон байна. ОНӨААН-үүдээс Шим-Ус ОНӨААТҮГ 11 жилд нийт 903 ажилтанд 106.7 сая төгрөгийг олгосон байна.

ТӨНӨААН-ийн албан хаагчдийн нийгмийн баталгаагаар хангасан байдал График 3




1.3.9 Нийгмийн баталгаа олгох хөтөлбөрийн дэмжлэгийг зарим албан хаагчдад олгохгүй байгаа нь иргэдийн тэгш эрхийг хангахгүй төдийгүй мэргэшсэн албан хаагчийн дутагдал үүсэхэд нөлөөлөл үзүүлж байна. Үүнд:

- Орон нутагт ажиллах санхүүгийн ажилчдын цалин бага, төрийн албан хаагчдад олгох 5 жилийн тэтгэмжийг санхүүгийн ажилтанд олгодоггүй, ачаалал хариуцлага ихээс санхүүгийн мэргэжилтэй хүний нөөц дутагдалтай,
- Насан туршийн боловсролын багш нар сургуульдаа харьяалагдаж тэтгэмжээ авч байгаа боловч Жаргалант, Булган сумдын насан туршийн төвийн багш нарт 3, 5 жилийн мөнгөн тэтгэмж Боловсролын ерөнхий хуулийн 13 дугаар зүйлийн 3.3-д тухайн нэршил байхгүй учраас олгогдохгүй,

**Сул орон тооны мэдээллийг олон нийтэд, ил тод нээлттэй байдлаар хүргэж ажилласан ч зарим төрийн үйлчилгээний албан тушаалтныг сонгон шалгаруулалтгүйгээр томилж байна**

1.3.10 Төрийн албаны зөвлөлийн 2023 оны 1 дүгээр сарын 25-ны өдрийн 25 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан "Төрийн албаны шалгалт өгөх болзол болон шатлан дэвшүүлэх, сонгон шалгаруулах журам"-ын 4-д заасны дагуу шалгалтын зарыг олон нийтэд мэдээлж, сул орон тоог нөхөж байна.



1.3.11 Тайлант хугацаанд давхардсан тоогоор төрийн захиргааны удирдах албан тушаалын 16, төрийн захиргааны 233 сул орон тоонд төрийн жинхэнэ албан хаагчийг шилжүүлэн ажиллуулах 11 удаагийн зар өгснөөс 5 сул орон тоог зарын дагуу нөхөж, шилжүүлэн ажиллуулах зарын дагуу нөхөгдөөгүй сул орон тоог нөхөх тусгай шалгалтыг журмын дагуу зохион байгуулж, давхардсан тоогоор төрийн үйлчилгээний төсвийн шууд захирагчийн 10, төрийн захиргааны удирдах албан тушаалын 16, төрийн захиргааны гүйцэтгэх албан тушаалын 228 сул орон тоог нөхөх тусгай шалгалтыг журмын дагуу зохион байгуулжээ.



1.3.12 Төрийн үйлчилгээний төсвийн шууд захирагчийн 7, төрийн захиргааны удирдах албан тушаалын 9, төрийн захиргааны гүйцэтгэх албан тушаалын 90 сул орон тоонд нэр дэвшүүлснээс 8 нэр дэвшигч өөрийн хүсэлтээр татгалзаж, 98 сул орон тоо нөхөгдсөн байна.



1.3.13 Эрүүл мэндийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.3<sup>12</sup>, 12 дугаар зүйлийн 12.2<sup>13</sup>-д заасны дагуу сумдын эрүүл мэндийн төвийн эрхлэгч эмч нарыг сумын Засаг дарга томилохдоо Эрүүл мэндийн даргатай зөвшилцөхгүйгээр шууд томилж байна.

1.3.14 Ховд АЗЗА ТӨХК нь мэргэжлийн боловсон хүчин аймагт дутагдалтай байдаг тул шаардлага хангасан хүн ирвэл сонгон шалгаруулалт зарлахгүйгээр шууд томилж, Ховд дулааны станц ТӨХК болон Ховд аймаг дахь Нисэх буудал нь стратеги төлөвлөгөө болон дотоод журамд заасны дагуу сул орон тоонд мерит зарчим баримталсан, дэвшүүлэн ажиллуулах боломжгүй бол нөөцөд байгаа иргэдээс авсан байна.

1.3.15 Төрийн үйлчилгээний байгууллагад гарсан сул орон тоонд ажилтан шалгаруулж авах тухай олон нийтэд мэдээлээгүй, мэдээлсэн гэх боловч холбогдох нотлох баримтаар тогтоогдохгүй байна. Тухайлбал:

- Төрийн үйлчилгээний албан тушаалын сул орон тооны мэдээллийг байгууллагын цахим хуудсаар мэдээлж дотоод журамд заасны дагуу төсөв захирагч шууд томилдог ч Дөргөн, Мянгад, Буянт, Алтай, ХХГБХГ, Цаг уур зэрэг газрууд ил тод мэдээлсэн мэдээлэл баримтаар нотлогдоогүй
- Булган сумын нэгдсэн эмнэлгийн удирдлагыг аймгийн Засаг дарга 2021 онд томилохдоо сонгон шалгаруулалт зарлаагүй, эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.3.2<sup>14</sup>-д заасан шаардлагыг хангаагүй хүнийг түр орлон гүйцэтгэгчээр томилсон,
- Зооноз өвчин судлалын төв, Буянт, алтай сумын ЭМТ-үүд нь шинэ ажилтан хэрхэн сонгон шалгаруулж авах талаар дотоод журам, байгууллагын стратеги төлөвлөгөөнд тусгаагүй,
- Булган сумын Нэгдсэн эмнэлэг болон БОЭТ нь Эрүүл мэндийн тухай хууль болон эмнэлгийн тусламж үйлчилгээний тухай хуульд заасан ТУЗ-ыг одоог хүртэл байгуулаагүй, бүтэц орон тоог Захирлын дэргэдэх зөвлөлөөр батлуулж байгаа нь холбогдох хууль зөрчсөн,
- Сумдын ЭМТ-үүд нь нөөц байхгүй сумын хэмжээнд мэргэжилтэй боловсон хүчин дутагдалтай зэрэг шалтгаанаар сонгон шалгаруулалт зарлахгүйгээр албан хаагчийг шууд ажлын байранд томилсон,
- Аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа зарим ОНӨААТҮГ-ууд нь шинэ ажилтан сонгон шалгаруулж авсан тухай баримт материалгүй, сонгон шалгаруулалт зарлаагүй,
- Буянт, Дөргөн, Мөст, Булган сумдын соёлын төвийн нөхөн томилогдсон зарим ажилтны анх ажилд орохдоо гаргасан өргөдөл, үнэлгээний хуудас, хамт олноор хэлэлцсэн баримт материал байхгүй байна.

**Төрд учруулсан хохирлыг уг шийдвэрийг гаргасан буруутай албан тушаалтнаар нөхөн төлүүлэх хуулийн хэрэгжилт хангалтгүй байна**

1.3.16 Төрийн албаны салбар зөвлөлөөс төрийн албан хаагчийг хууль бусаар чөлөөлсөн, томилсон, халсныг шүүх тогтоосон төрд учирсан хохирлыг төлүүлэх нэхэмжлэл гаргах,

<sup>12</sup> Сум, тосгоны эрүүл мэндийн төвийн даргыг тухайн шөтний Засаг дарга, аймгийн эрүүл мэндийн газрын даргатай зөвшилцөж томилж, чөлөөлнө

<sup>13</sup> Аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газрын дарга нь тухайн шөтний Засаг даргатай зөвшилцөж, харьяа нэгдсэн эмнэлгээс бусад эрүүл мэндийн байгууллагын даргыг хууль тогтоомжид заасны дагуу томилж, чөлөөлнө.

<sup>14</sup> Эрүүл мэндийн байгууллагад тавьаас доошгүй жил удирдах албан тушаалд ажилласан

хэрэгжилтийг хангуулах баримт материалыг Төрийн албаны зөвлөлд хүргүүлсэн байна.

1.3.17 Төрийн албаны тухай хуулийн 50 дугаар зүйлийн 50.1 -д заасны дагуу тус ажиллагааг Төрийн албаны зөвлөлийн маргаан хянан шалгах газар хариуцан гүйцэтгэж байна. Төрд учирсан 2018-2023 онуудад тогтоогдсон шүүхийн шийдвэрийг хүснэгтээр харуулбал:

Ховд аймаг ТАГ-ын ЗЕХ-ийн 103-тай холбоотой асуудлын бүртгэл /Хүснэгт-1/

Он	Хүний тоо	Шүүхээр тогтоосон мөнгөн дүн /сая төгрөг/	Төлбөр барагдуулсан	Үлдэгдэл /сая төгрөг/
2018-2023	60	297	0	297

Эх сурвалж: Шүүхийн шийдвэрүүд

1.3.18 Төрийн албанаас хууль бусаар халагдсан төрийн албан хаагчтай холбоотой төрд учруулсан хохирлын нөхөн төлөлтөд хяналт тавьж, нөхөн төлөгдөөгүй тохиолдолд төрийг төлөөлж шүүхэд нэхэмжлэл гаргасан материал Төрийн албаны зөвлөлөөс ирүүлээгүй байна.

1.3.19 Төрийн албан хаагчийг хууль бусаар чөлөөлсөн, халсан, түр чөлөөлснийг шүүхээр тогтоож төрд учирсан хохирлыг барагдуулах 60 албан хаагчтай холбоотой 297.0 сая төгрөгийн хохирол барагдаагүй байна

1.3.20 Төрийн албаны "ХНУМТ" цахим системийг Ховд аймгийн 172 байгууллага ашиглаж, албан хаагчдынхаа дэлгэрэнгүй судалгаа, мэдээллийг хөтөлж байна. Салбар зөвлөл Ховд аймаг дахь төрийн албан хаагчийн 2013-2023 оны тоо бүртгэлийн дэлгэрэнгүй мэдээллийг нэгтгэж, хяналт тавин ажилласан байна.

## **БҮЛЭГ 2: ЦАХИМ МЭДЭЭЛЛИЙН ТОГТОЛЦООГ НЭВТРҮҮЛСНЭЭР ТӨРИЙН АЛБАНЫ ИЛ ТОД БАЙДАЛ САЙЖИРСАН Ч ЗАРИМ ТӨРИЙН АЛБАН ХААГЧ НАРЫН АЖЛЫН ХАРИУЦЛАГА, МЭДЛЭГ ЧАДВАР СУЛ БАЙНА**

**Орон зайнаас үл хамааран мэдээ, мэдээллийг тухай бүр авч өөрийн мэдлэг чадвараа дээшлүүлэх боломж бүрдсэн байна**

2.1.1 Тайлант оны сургалтын төлөвлөгөөнд тусгагдсанаар Засгийн газрын зорилтот сургалтад 340, Төрийн албаны зөвлөлийн "Арга зүйн сургалт"-д 11583, Удирдлагын академийн богино хугацааны зорилтот сургалтад 200, мэргэжлийн бусад байгууллагын сургалтад 1776 албан хаагч тус тус хамрагдсан байна.

2.1.2 Төрийн албан хаагчийг мэргэшүүлэх багц сургалтууд, Төрийн албаны зөвлөлийн "7.4:10 арга зүйн сургалт"-ууд 100 хувь цахимаар явагдаж тайлант онд давхардсан тоогоор 11583 албан хаагч хамрагдаж, төрийн албан хаагчийг мэргэшүүлэх багц сургалтад 84 албан хаагч суралцаж төгссөн нь зайнаас үл хамааран цахимаар суралцах боломжийг бүрдүүлсэн байгаа нь төрийн албан хаагчид цаг хугацаа, санхүүгийн хувьд хэмнэлттэйгээс гадна орон зайнаас үл хамааран мэдээ, мэдээллийг тухай бүр авч өөрийн мэдлэг чадвараа дээшлүүлэх боломжийг бүрдүүлж өгчээ.

2.1.3 Эрүүл мэндийн салбарын албан хаагчид нь эрүүл мэндийн хөгжлийн төвөөс зохион байгуулж буй HRD программ хангамжаар дамжуулан тасралтгүй сурч хөгжих, кредит оноо цуглуулах, эмчлэх эрхийн зөвшөөрөл сунгах зэрэг орон зайнаас үл хамааран сурах, өөрийгөө хөгжүүлэх боломжтой болсон байна.

2.1.4 Ховд аймаг дахь Нисэх буудал нь нислэгийн аюулгүй байдлыг хангах чиглэлээр Иргэний нисэхийн үндэсний төвөөс зохион байгуулж байгаа сургалтад тогтмол

хамрагдсан, Шим-Ус ОНӨААТҮГ нь Монголын нийтийн ахуй үйлчилгээний холбоо болон Усны үйлчилгээг зохицуулах хорооноос зохион байгуулж байгаа сургалтад инженер, техникийн ажилчдаа тогтмол хамруулан сургаж байна

2.1.5 Соёлын байгууллагууд нийгмийн хамгааллын болон сургалт хөгжлийн хөтөлбөрийг боловсруулан баталсан боловч тус хөтөлбөрүүдийн хүрсэн үр дүн, биелэлт тооцоогүй, ажлын тайлан байхгүй байна.

**Албан тушаалын тодорхойлолтод заасан тусгай шаардлагыг хангасан төрийн албан хаагчдыг сэлгэн томилсон байна**

2.1.6 Төрийн албаны зөвлөлийн 2023 оны 1 дүгээр сарын 25-ны өдрийн 25 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан "Төрийн албаны шалгалт өгөх болзол болон шатлан дэвшүүлэх, сонгон шалгаруулах журам"-ын 4-д заасны дагуу шалгалтын зарыг олон нийтэд мэдээлж, газар зүйн байршлаас үл хамааран мэдлэг чадвартай албан хаагчийг шилжүүлэн ажиллуулж байна

2.1.7 Газарзүйн байршлаас үл хамааран албан тушаалын тодорхойлолтод заасан тусгай шаардлагыг хангасан сэлгэн шилжүүлсэн байна. Хүснэгтээр харуулбал:

Төрийн албан хаагчийг сэлгэн ажиллуулсан томилгоо			/Хүснэгт-3 /	
Албан тушаал	Ангилал, зэрэглэл	Үндэслэл	Шийдвэр-ийн огноо, дугаар	Хүний тоо
Мэргэжилтэн	Дэс түшмэл, ТЗ-7	Төрийн албаны тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.1 дэх хэсэг, ТАЗ-ийн 2023 оны 25 дугаар тогтоолоор баталсан журмын 4.2 дахь заалт	2023.09.13 6/34	3
Мэргэжилтэн	Дэс түшмэл, ТЗ-8	Төрийн албаны тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.1 дэх хэсэг, ТЖАХ-ийг өөр албан тушаалд шилжүүлэх, сэлгэн ажиллуулах журмын 2.5 дахь заалт	2023.09.13 6/35	8
Мэргэжилтэн	Дэс түшмэл, ТЗ-9	Төрийн албаны тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.1 дэх хэсэг, ТАЗ-ийн 2023 оны 25 дугаар тогтоолоор баталсан журмын 4.2 дахь заалт	2023.09.13 6/36	12

**Мэдээллийн технологийн чиглэлийн мэргэжилтэн хөдөө сумдад дутагдалтай байна**

2.1.8 Байгаль орчны газар, Нийгмийн даатгалын газар, Улсын бүртгэлийн хэлтэс, Ус, цаг уур, орчны шинжилгээний төв, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, Хүнс, хөдөө аж ахуйн газар, Эрүүл мэндийн газар нь байгууллагынхаа ажлын онцлогоос хамааран мэдээлэл технологийн ажилтныг албан тушаалын тодорхойлолтод заасны дагуу шалгаруулж томилсон байна.

2.1.9 Эрүүл мэндийн даатгалын хэлтэс, Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газар, Орон нутгийн өмчийн газар, Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба, Соёл, урлагийн газар, Стандарт, хэмжил зүйн хэлтэс, Статистикийн хэлтэс, Татварын хэлтсүүд чиг үүрэг, бүтцэд орон тоо батлагдаагүй учир бие даасан мэдээллийн технологийн ажилтангүй үйл ажиллагаа явуулж байна.

2.1.10 Засаг даргын 2023 оны 04 дүгээр сарын 27-ны өдрийн "Сумдын Засаг даргын Тамгын газрын бүтэц орон тоог шинэчлэн батлах тухай" А/201 дүгээр захирамжаар 16 суманд "Мэдээллийн технологи, төрийн үйлчилгээний нэгдсэн систем хариуцсан

ажилтан"-г төрийн үйлчилгээний албан тушаалын ангилалд ажиллуулахаар баталсан байна.

2.1.11 Орон нутагт мэдээлэл технологийн мэргэжилтэн дутагдалтайгаас сонгон шалгаруулалтаар шаардлага хангахгүй ажилтан томилогдсон байна. Тухайлбал:

- Аймгийн 17 сумын мэдээлэл технологийн ажилтны албан тушаалын тодорхойлолтын "тухайн албан тушаалд тавигдах тусгай шаардлага"-ыг жишгээр баталж өгөөгүй учраас Жаргалан, Хөвд сумдаас бусад 15 сум нь мэргэжил таарахгүй, тухайн ажилд авах иргэнд зориулсан албан тушаалын тодорхойлолт боловсруулсан,
- Буянт, Дарви сумдын Засаг даргын Тамгын газар Хууль эрх зүй, дотоод асуудал хариуцсан мэргэжилтэн буюу төрийн захиргааны албан хаагчид төрийн үйлчилгээний албан тушаалыг хавсран гүйцэтгүүлж цалингийн хувь олгосон,
- Манхан, Мөст, Зэрэг, Үенч, Эрдэнэбүрэн сумд албан тушаалын тодорхойлолтын мэргэжил хэсэгт "Эрх зүй, Нягтлан бодогч, Зураглаач, Хятад хэлний орчуулагч"-ийн мэргэжил заасан нь тухайн ажилд авсан албан хаагчид зориулж боловсруулсан,
- Мэдээллийн технологийн мэргэжилтний албан тушаалтын тодорхойлолтын мэргэжил хэсэгт Алтай, Дуут сумд "Мэдээлэл, харилцаа, холбооны технологи (061), мэдээллийн боловсрол (0114)" Мөнххайрхан сум "Мэдээлэл, харилцаа холбооны технологиуд, график дизайнер, компьютерын инженерчлэл, программ хангамжийн инженерчлэл"-ийн мэргэжилтэй гэж заасан боловч Алтай сум ХААИС-ийг "статистикч, эдийн засаг", Дуут сум ХААИС-ийг "Зоо инженер", Мөнххайрхан сум "Байгаль орчныг хамгаалах технологи" мэргэжлээр төгссөн иргэнийг тус тус томилсон,
- Булган, Дөргөн, Цэцэг, Чандмань сумдын сул орон тоо нөхөгдөөгүй зэрэг зөрчлүүд нь мэдээллийн технологийн чиг үүрэг хэрэгжүүлдэг хүний нөөц бүрдүүлэх хүрээнд боловсон хүчнийг сургаж дадлагажуулж бэлтгэх шаардлагатай байгааг харуулж байна

**Жендерийн тэгш байдлыг хангах дэд хөтөлбөрийг боловсруулан батлуулсан ч хүрсэн түвшин, үр дүнг тооцоогүй байна**

2.1.12 Аймгийн Статистикийн мэдээллээр хүйсээр ангилан гаргаж байгаа мэдээллийг сумдын захиргааны байгууллагаар түүвэрлэн үзэхэд нутгийн захиргааны байгууллагын 592 ажиллагсаас 267 эмэгтэй, 325 нь эрэгтэй ажиллагсад байна.

2.1.13 Аймгийн ИТХ-ын төлөөлөгчдийн 17.1 хувь, аймаг сумдын ЗДТГ-ын дарга нарын 35.2 хувь нь эмэгтэйчүүд байна.

2.1.14 Жендерийн тэгш байдлыг хангах дэд хөтөлбөрийг баталсан ч хөтөлбөрийн хэрэгжилтийг өмнөх онуудтай харьцуулан дүгнэлт өгч, арга хэмжээний шалгуур үзүүлэлтийг хүрэх түвшинтэй уялдуулан, ямар үр нөлөө үзүүлснийг тодорхой, тоо баримттай тайлагнаагүй байна.

2.1.15 Хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажил эрхлэлтийн мэдээлэл, төрийн үйлчилгээг авах боломж, эрхийн талаар авч хэрэгжүүлсэн бодлого байхгүй байна.

**Хөдөө орон нутагт боловсон хүчин дутмагаас эрэлт ихтэй улсын бүртгэлийн үйлчилгээ, газрын үйлчилгээг авахад чирэгдэл үүсэж байна**

2.2.1 Нэг цонхны үйлчилгээг аймгийн нутгийн удирдлагын оронд ажиллуулж, Улсын бүртгэлийн хэлтсийн Жаргалант сумын 2 бүртгэлийн байцаагч 12 төрлийн үйлчилгээгээр, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын 3 мэргэжилтэн 15 төрлийн үйлчилгээгээр, нийт 5 мэргэжилтэн 27 төрлийн үйлчилгээгээр иргэдэд үйлчилж байна.

2.2.2 Хөдөөгийн сумдын иргэдэд хүргэх төрийн үйлчилгээг ойртуулан Улсын бүртгэлийн хэлтсийн 24 үйлчилгээ, Авто тээврийн газрын 2 үйлчилгээ, Гаалийн газрын 1 үйлчилгээ, Татварын 5 үйлчилгээ, Цагдаагийн газрын 7 үйлчилгээ, ШШГТ-ын 1 үйлчилгээ, Нийгмийн даатгалын 4, Эрүүл мэндийн газрын 1 үйлчилгээ, Хөдөлмөр халамжийн үйлчилгээний

газрын 5 үйлчилгээ, Боловсрол соёлын газрын 3 үйлчилгээ нийт 54 үйлчилгээг сум бүртээ авах боломжийг бүрдүүлжээ

2.2.3 Хөдөө орон нутагт боловсон хүчин дутмаг, цахимаар зарим үйлчилгээг иргэд авах боломж бага байгаагаас эрэлт ихтэй улсын бүртгэлийн үйлчилгээ, газрын үйлчилгээ авах шаардлагаар аймаг явж зардал чирэгдэл, цаг хугацаа алдаж байна.

### **Цахим мэдээлэл солилцооны нэгдсэн системийг төрийн байгууллагуудын үйл ажиллагаанд нэвтрүүлсэн байна**

2.2.4 Засгийн газраас хэрэгжүүлж буй "Шинэ сэргэлтийн бодлого"-ын нэг төрийн бүтээмжийг нэмэгдүүлж, төрийн үйлчилгээг иргэдэд ойртуулах зорилгоор аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан "Иргэдэд хүргэх төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх" зорилтын хүрээнд дараах ажлуудыг хийж хэрэгжүүлсэн байна. Тухайлбал:

- ✓ Аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Ховд аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэлд тусгагдсан мэдээлэл, харилцаа холбооны орчин үеийн технологи, цахим мэдээлэл солилцооны нэгдсэн систем, "smart khovd" гар утасны аппкейшн, нэг биллийн систем зэрэг технологийн дэвшил, инновац нэвтрүүлэхээр тусган, хэрэгжүүлж эхэлсэн,
- ✓ Төрийн үйлчилгээний нэгдсэн портал [www.erp.e-mongolia.mn](http://www.erp.e-mongolia.mn) нэвтрүүлсэн бөгөөд e-Mongolia системд төрийн 21 байгууллагын 66 үйлчилгээг цахимжуулж, нэгтгэсэн нь нэг шатлалт буюу иргэн гар утас, суурин компьютероосоо цаг хугацаа алдахгүй шууд авах боломжтой лавлагаа, тодорхойлолт болон олон шатлалт үйлчилгээ буюу тусгай зөвшөөрөл, бичиг баримт захиалах зэрэг үйлчилгээнүүд орсон,
- ✓ Төрийн цахим үйлчилгээ үзүүлэх "Хурдан" төв байгуулснаар иргэд 39 байгууллагын 440 үйлчилгээг 10-15 минутын дотор авах боломж бүрдэж, цахимд шилжсэнээр үйлчилгээний шат дамжлага буурч, ирээдэд илүү хүртээмжтэй болсон

2.2.5 Шинэ сэргэлтийн бодлого, төрийн бүтээмжийн сэргэлт, Цахим Ховд бодлогыг хэрэгжүүлэх хүрээнд Хяналт-шинжилгээ, үнэлгээний мэдээллийн цахим санг нэвтрүүлснээр 20 бодлогын баримт бичиг болон хууль тогтоомж, тогтоол шийдвэр, аймгийн удирдлагаас өгсөн шуурхай үүргийн хэрэгжилтийг Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлагууд болон төсөвт байгууллагууд, сумдын Засаг даргын Тамгын газар, орон нутгийн өмчит үйлдвэрийн газрууд зэрэг 55 байгууллагад нэвтрүүлснээр төрийн байгууллагуудын 95 хүртэл хувь нь мэдээлэл солилцоход саадгүй болсон байна.

2.3.1 Аймгийн хэмжээнд төрийн болон нутгийн захиргааны байгууллагуудад <https://erp.e-mongolia.mn> дотоод удирдлагын нэгдсэн систем нэвтрүүлж, 296 төрийн албан хаагч өдөр тутмын үйл ажиллагаандаа ашиглан, мэдээллийг шуурхай солилцож, цаг ашиглалт, ажлын бүтээмжээ нэмэгдүүлж, дотоод нэгдсэн сүлжээгээр албан бичгийг шуурхай солилцон, мэдээллийн дижитал урсгалыг сайжруулсан байна.

### **Төрийн үйлчилгээний ил тод байдалд хөндлөнгийн байгууллага хяналт хэрэгжүүлээгүй байна**

2.3.2 Төрийн байгууллагуудын үйл ажиллагааны нээлттэй, ил тод байдлыг сайжруулах зорилгоор аймгийн Засаг даргын Тамгын газрын даргаар 2020 оны 03 дугаар сарын 12-ны өдөр батлуулсан "Ховд аймгийн төрийн байгууллагуудын цахим мэдээлэл ба ил тод байдлын хэрэгжилтийн явцад хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх ажлын удирдамж"-ийн дагуу Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль, Засгийн газрын 2013 оны 411 дүгээр тогтоолоор баталсан "Мэдээллийн ил тод байдлыг хангах нийтлэг журам", 2017 оны 89 дүгээр тогтоолын 11 дүгээр хавсралтаар баталсан ил тод байдлын шалгуур үзүүлэлтээр хяналт хэрэгжүүлсэн ч үр дүнг дүгнээгүй байна.

2.3.3 Ховд их сургуулийн дэргэдэх Баруун бүсийн тогтвортой хөгжлийн хүрээлэнгээс 2018 онд "Төрийн үйлчилгээний чанар, хүртээмжид өгөх хэрэглэгчийн үнэлгээ" сэдвээр 5 хүний бүрэлдэхүүнтэй төрийн үйлчилгээ, хүртээмж, харилцаа хандлагад судалгаа хийн тайланг аймгийн Засаг даргад ирүүлсэн байна. Судалгаанд оролцсон иргэдийн санал асуулгыг нэгтгэлийг хүснэгтээр харуулбал:

Төрийн үйлчилгээний ил тод байдалд хийсэн мониторинг							/Хүснэгт-4/
№	Үзүүлэлтүүд	Маш муу	Муу	Дунд	Сайн	Маш сайн	Хариулаагүй
1	Үйлчилгээний чанар	180	1117	5375	3784	409	375
2	үйлчилгээний хүртээмж	139	923	4458	2833	309	313
3	Харилцааны соёл, ёс зүй	153	965	4462	2845	320	315
4	Үйлчилгээний орчин	350	1379	6019	4667	692	455
Үйлчилгээний хүртээмжийн ерөнхий дундаж үнэлгээ							3.4
Ерөнхий үнэлгээ						30%	22%

Эх сурвалж: Тогтвортой хөгжлийн хүрээлэнгийн тайлан

2.3.5 "Хариуцлагатай тунгалаг төр", Цахим ховд хөтөлбөрийг хэрэгжүүлснээр мэдээллийн нээлттэй, ил тод байдлыг сайжруулах ажлыг эрчимжүүлэх, төрийн байгууллагын үйл ажиллагаанд иргэд олон нийтийн оролцоог хангах нөхцөлийг бүрдүүлсэн эсэх, төрийн байгууллагууд цахимд шилжсэнээр ажлын бүтээмжийн үр дүн гарч байгаа эсэхэд сүүлийн жилүүдэд хөндлөнгийн хяналт хийгдээгүй байна.

**Аудитаар нийт 376.1 сая төгрөгийн зөрчил илэрснээс 297.0 сая төгрөгийн 1 албан шаардлага, 79.1 сая төгрөгийн алдаа зөрчилд 6 зөвлөмж өгөгдлөө.**

#### ЕРӨНХИЙ ДҮГНЭЛТ

- Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20.1.5, 21.1.6, 22.1.6-д заасан чиг үүргээ шат шатны Засаг дарга нар хэрэгжүүлээгүйгээс төрийн байгууллагууд нь хүний нөөцийн бодлогын баримт бичгийг боловсруулан батлуулаагүй нь боловсон хүчний хөдөлгөөн тогтворгүй, мэргэжил, мэргэшил, туршлагын шаардлагыг хангасан хүний нөөцийн бодлого алдагдсан
- Төрийн үйлчилгээний нэгдсэн тогтолцоог бүрдүүлэн бэхжүүлэх, дундын өгөгдлийн системийг бий болгон хөгжүүлэх, орчин үеийн дэвшилтэт техник, технологийг нэвтрүүлэх, үйлчилгээний хүртээмж, шуурхай байдлыг сайжруулахад ахиц гарч, мэдээллийн нэгдсэн сангийн нууцлал, аюулгүй байдлыг хангасан ч хөдөөгийн болон тусгай хэрэгцээт иргэд мэдээлэл авах боломж бүрэн бүрдээгүй байна
- Төрийн албан хаагчийн гүйцэтгэлийг төлөвлөх, тайлагнах, үнэлэх үйл ажиллагаа Засгийн газраас батлагдсан журмын хүрээнд хийгдэж байгаа боловч төрийн үйлчилгээний албан тушаалтнуудад олгох нийгмийн баталгаа хангах хөтөлбөр холбогдох хуулиудад харилцан адилгүй үйлчилж байгаа нь төрийн албан хаагч тогтвор суурьшилтай ажиллахад эерэг нөлөө үзүүлэхгүй байна
- Төрийн албаны тухай хууль болон бусад эрх зүйн акт хэрэгжих нөхцөл, төрийн үйлчилгээг хүргэх салбарынхаа цар хүрээ, хүний нөөцийн хүрэлцээ, хангамжийг харгалзахгүй орон нутгийн албан хаагчдын албан тушаалын тодорхойлолтын мэргэжлийн шаардлагыг оновчгүй тодорхойсноос мэргэжлийн тусгай

шаардлагад нийцээгүй иргэдийг сонгон шалгаруулах, эсвэл ажиллах боловсон хүчин дутагдах нөхцөл үүссэн

- Хүний нөөцийн ажилтны орон тоо төрийн байгууллагуудад батлагдаагүйгээс нэг ажилтанд ажил хавсруулан хийлгэснээр хүний нөөцийн бодлогын зарчим алдагдаж хүний нөөцийн мэдээллийн сан үнэн зөв бүрдэхгүй байх, санхүүгийн төлөвлөлт буруу хийгдэх, зөв зохистой шийдвэр гаргахад нөлөөлж байна
- Байгууллагын журам, үйлчилгээний стандарт, төрийн албан хаагчийн хувийн хэргийг бүрдүүлэх, хянах, баяжуулах, хадгалах, шилжүүлэх, хувь хүний хуулиар хамгаалагдсан нууцыг хадгалгах үйл ажиллагаа журмын хэрэгжилтийг бүрэн хангаагүй, дотоод болон хөндлөнгийн хяналт шалгалтын үр нөлөөг зохих ёсоор гаргаж ажиллаагүй
- Албан тушаалтны буруутай шийдвэрийг шүүхээр тогтоож төрөөс иргэдэд олгосон нөхөн төлбөрийг төрд учруулсан хохирлыг буруутай этгээдээр төлүүлэхэд хяналт тавьж ажиллаагүй, нөхөн төлөгдөөгүй тохиолдолд төрийг төлөөлж шүүхэд нэхэмжлэл гаргаагүй байна

## АУДИТЫН ЗӨВЛӨМЖ

Гүйцэтгэлийн аудитын дүн дүгнэлтэд үндэслэн дараах зөвлөмжийг хүргэж байна.

### Ховд аймгийн Засаг дарга М.Амарсанаа танаа

1. Засаг даргын эрхлэх хүрээний байгууллагуудын мэдээллийн ил тод байдал, хүний нөөцийн бодлого, орон тоо, чиг үүргийн бүтэц, гүйцэтгэлийн үнэлгээнд хяналт хэрэгжүүлж албан хаагчдын ажлын хариуцлагыг дээшлүүлэх
2. Төрийн үйлчилгээг цахимаар авах мэдээллийг хөдөөгийн иргэд, сонсголын болон харааны бэрхшээлтэй хүмүүс хэрхэн авах, ашиглах талаар сургалт сурталчилгаа хийж төрийн үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлэх
3. Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан төрийн байгууллагуудын үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлэх, албан хаагчдын чадвар, хариуцлагыг дээшлүүлэхээр хэрэгжүүлсэн хөтөлбөр арга хэмжээний хүрсэн үр дүнг тооцох

### Төрийн албаны салбар зөвлөлийн дарга Б.Сандагсүрэн танаа

1. Төрийн байгууллагуудын хүний нөөцийн орон тоог батлуулах, хүний нөөцийг давхар хариуцсан ажилтнуудын ажлын хариуцлагыг сайжруулах, хүний нөөцийн хүрэлцээ, хангамжийг харгалзан орон нутгийн албан хаагчдын албан тушаалын тодорхойлолтын мэргэжлийн шаардлагыг оновчтой тодорхойлж мэргэжлийн тусгай шаардлагад нийцээгүй иргэдийг сонгон шалгаруулахгүй байх
2. Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн дагуу хүний нөөцийн бодлогын баримт бичгийг боловсруулахдаа судалгаа шинжилгээний үндэслэлтэй, "Алсын хараа-2050", Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, чиглэл, төрийн албаны шинэтгэлийн бодлого, албан хаагчийн цогц чадамжийг хангах чиглэлийг анхааран тусгаж, батлуулах

3. Төрийн байгууллага болон орон нутгийн өмчит газруудын стратеги төлөвлөгөө, хүний нөөцийн бодлого, албан тушаалын тодорхойлолт болон байгууллагын дүрэм, журам, үйлчилгээний стандарт, төрийн албан хаагчийн хувийн хэргийг бүрдүүлэх, хянах, баяжуулах, хадгалах, шилжүүлэх, хувь хүний хуулиар хамгаалагдсан нууцыг хадгалгах үйл ажиллагаа журмын хэрэгжилтэд хяналт хэрэгжүүлж ажлын хариуцлагыг дээшлүүлэх

### ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

## ШАЛГАГДАГЧ БАЙГУУЛЛАГААС ИРҮҮЛСЭН ТАЙЛБАР



ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН  
ХОВД АЙМАГ ДАХЬ  
САЛБАР ЗӨВЛӨЛ

ХТТХЗ-ийн Хувьсгал

Утас/Факс: 7742-2106, Email: [khuvtsag@khuvtsag.gov.mn](mailto:khuvtsag@khuvtsag.gov.mn)

2024.12.05 № 286

Өндөр \_\_\_\_\_ Өмнө \_\_\_\_\_

ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН  
ГАЗРЫН ДАРГА Х.БОЛДБААТАР ТАНАА

"Төрийн байгууллагын хүний нөөцийн бодлого, тогтоолцооны үр нөлөө" сэдэвт гүйцэтгэлийн аудитын тайлантай танилцлаа.


Төрийн албаны зөвлөлийн Ховд аймаг дахь салбар зөвлөлөөс тайланд өгөх санал байхгүй болно.

ДАРГА

Б.САНДАГСҮРЭН

8430015 2024 А/Б КН

ТУШААЛ:



Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчилтийн нэгтгэл

Аудитын нэр: Төрийн байгууллагын хүний нөөцийн бодлого, тогтоолуудын үр нөлөө

Шалгалдагч байгууллагын нэр: Засаг даргын зөвлөлийн хүрээний төрийн байгууллагууд, Төрийн болон ОНБУГ

Аудитын код: ХОА-2024-19-20-ШТА-ГА

№	Зорилго, чиглэл	Алдаа зөрчлийн тоо	Алдаа зөрчлийн товч үгс	Мөнгөн дүн (млн.төгрөгөөр)	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Байгууллагын санал	Аудиторын гаргасан шийдэл
А			1	4	5		9
1	1.3.4 Төрийн албан хаагчийн эрх зөрчигдөж, төрд хохирол учруулсан байна уу?	1	Албан тушаалтны бүрүүтэй шийдвэрийг шүүхээр тогтоож төрөөс иргэдэд олгосон нөхөн төлбөрийг төрд учруулсан хохирлыг буруутай аргаар төлүүлэхэд хяналт тавьж ажиллалагүй, нөхөн төлбөрийг төлөгчид төрийн төлбөрт шүүхэд нэмэгдэл гаргаагүй	297,000.0	Албан шаардлага		
2	2.3.2 Төрийн үйлчилгээний мт тод нээлттэй байдалд холбогдсон байгууллагууд судалгаа хийж, хяналтын үр нөлөөтэй тогтолцоо бүрдсэн үү?	1	Төрийн байгууллагын чиг үүрэг, албан тушаалын даавардал, үйлчилгээний стандарт, төрийн албан хаагчийн хувийн эрхийг бүрэлдүүлэх, мөхөж, боловсруулах, задлага, шилжүүлэхэд дотоод болон гадаадын хяналт шалгалтын үр нөлөөг зохиох ёсоор гаргах үр дүнг хэсрүүлж	-	Зөвлөмж		
3	1.3.2 Төрийн албан хаагчийг тогтвор суурьшилтай ажиллуулах, нийгмийн баталгаажуулах зорилготой байна уу?	1	Төрийн үйлчилгээний албан тушаалтнуудад олсон нийгмийн баталгаа хяналт хөндөгч хуулиудад харилцан адилгүй үйлчилж байгаа нь төрийн албан хаагч тогтвор суурьшилтай ажиллах нөхцөл бүрдээгүй	-	Зөвлөмж		
4	1.1.2 Батлагдсан үйл ажиллагааны стратеги, зохион байгууллагын бүтцийг төрийн байгууллагууд мөрдөн ажиллаж байна уу?	1	Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тусгай хуульд заасан чиг үүрэгт шат шатны Засаг дарга нар хэрэгжүүлээгүйгээс төрийн байгууллагууд нь хүний нөөцийн бодлогын баримт бичгийг боловсруулан батлуулжээгүй	-	Зөвлөмж		
5	2.2. Иргэд төрийн үйлчилгээг орон зайнаас үл хамааран авах нөхцөл боломж бүрдсэн үү?	1	Төрийн үйлчилгээний нэгдсэн тогтолцоог буруутган цогцмоор болон тусгай эрх зорилготой иргэд мэдээлэл авах боломж бүрэн бүрдээгүй	-	Зөвлөмж		
6	1.2.1 Төрийн байгууллагын хүний нөөц нь хуралцдагтай байна уу?	1	Хүний нөөцийн амлалтын орон тоо төрийн байгууллагуудад батлагдаагүйгээс нэг ажилтанд ажил хэвсгүүрэн хайлснаар хүний нөөцийн бодлогын зарчмыг алдагдан хүний нөөцийн мэдээллийн сан үнэн зөв бүрдээгүй байж, санхүүгийн төлөвлөлт буруу хийгдэж, зөв эхистэй шийдвэр гаргахад нөлөөлж төрийн мэдээллийн орон тоо нөхөлдөггүй хүний нөөцийн дугаардал үүссэн	79,119.5	Зөвлөмж		
7	1.2.3 Төрийн байгууллагын үйлчилгээг хуралцдагтай байхад төрийн хуульчилсан хийж байна уу?	1	Төрийн үйлчилгээг хуралцдагтай байхад төрийн хуульчилсан хийж байна уу?		Зөвлөмж		
				376,119.5			

Зөрчлийн нэгтгэл бүрдүүлсэн: Д.Эрдэнэцэцэг  
 Ахлах аудитор: Д.Мөнхтүлэ  
 Аудитор: Д.Энхжаргал  
 Аудитор: Ц.Азаяа  
 Анхны шалтанд хариуцаж: А.Цэцэгсүрэн  
 Хэлтсийн дарга бөгөөд аудитын менежер: А.Цэцэгсүрэн  
 Хоёр дахь шатанд хариуцаж: А.Цэцэгсүрэн  
 Дарга бөгөөд тэрүүлэгч аудитор: А.Цэцэгсүрэн

Төлөөлөгч хүлээн зөвшөөрсөн:  
 Ховд амлгийн ТАСЗ-ийн дарга: Б.Сандагсүрэн  
 ТАСЗ-ийн нарийн бичгийн дарга: Б.Гантөмөр

PHO-A-0073 00066454